БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

## Баянбулаг сумын ИТХурал 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код:** БНА-2019/12/СТА-ТШ3

Цахим хуудас: www.audit.mn
Баянхонгор сум 2019 он


Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат
Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn
Аудитын менежер: Д.Цэцэгмаа
Утас: 88089024 Цахим хаяг: tsetsegmaadam@audit.gov.mn
Аудитор: Г.Ганчимэг
Утас: 88268424 Цахим хаяг: ganaa_7133@yahoo.com


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

# Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт |
| АДБОУС | Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт |
| АОУС | Аудитын олон улсын стандарт |

## Агуулга


1 Аудитын гэрчилгээ ........ 3

2 Аудитын тайлан ........ 5

2.1 Оршил ........ 5

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага ........ 5

2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт ........ 6

2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин ........ 6

2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ ........ 7

2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал ........ 8

2.7 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар ........ 8

2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн ........ 9

2.8.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал ........ 9

2.9 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал........ 9

2.10 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга ........ 10

2.11 Шилэн дансны мэдээлэл ........ 10

2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга ........ 10

2.13 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл ........ 10

3. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ........ 10

3.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ........ 10

3.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ........ 11

3.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан ........ 12

3.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ........ 14

3.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ........ 14

# 1 Аудитын гэрчилгээ

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
64101 Номгон, Баянхонгор сум
Утас, факс 70-44-25-84
E-mail; bayankhongor@audit.gov.mn

2019.02.25 № 2/56

танай ______________ -ны № ______________ -т

БАЯНБУЛАГ СУМЫН ИТХ-ЫН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА Ч.ГАНБОЛД ТАНАА

**Аудитын гэрчилгээ**

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Баянбулаг сумын ИТХ-ын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Баянбулаг сумын ИТХ-ын  2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар  Баянбулаг сумын ИТХ-ын 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн

2519094

бодлого, бүртгэлийн хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад  санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

**Үүрэг хариуцлага**

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т заасны дагуу тайлант хугацааны  санхүүгийн тайлан, тодруулгыг  Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудитыг хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.МӨНХБАТ

D:\Purevdagva MUNKH-ERDENE\Munkherdene_2019\STA_2018\STA-Baiguullaga\ТШЗ-13\6.Баянбулаг ИТХ\3.Тайлагнал\Bayanbulag_ITH_Gerchilgee.Docx

# АУДИТЫН ТАЙЛАН

## 2.1 ОРШИЛ

Баянбулаг сумын ИТХ-ын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Баянбулаг сумын ИТХ-ын нарийн бичгийн дарга Ч.Ганболд-д танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

## 2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянбулаг сумын ИТХ-ын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянбулаг сумын ИТХ-ын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 02 дугаар сарын 24-нөөс 2019 оны 02 дугаар сарын 25-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 02 дугаар сарын 25-ний өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газрын аудитор Г.Ганчимэг хариуцаж хэрэгжүүлэв.

Баянбулаг сумын ИТХ-ын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газарт 2019 оны 01 дүгээр сарын 25-ний өдрийн 01 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

## 2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

## 2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Баянбулаг сумын ИТХ-ын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго: Баянбулаг сумын ИТХурал нь Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын үйл ажиллагааг ард иргэдэд сурталчлан таниулах, эдийн засаг, нийгмийн асуудлыг тууштай шийдвэрлэн хэрэгжилтэд хяналт тавих, орон нутагтаа хэтийн бодлого, шийдвэрийг тодорхой чиглэлтэйгээр хөгжүүлэх, Ард иргэдийнхээ ая тухай ажиллаж амьдрах, нөхцөлийг бүрдүүлэхийн төлөө хурлын ил тод нээлттэй байдлыг ханган төлөөлөгчдийн үүрэг хариуцлагыг өндөржүүлэн иргэдийн төлөөллийн байгууллагыг бүрэн утгаар төлөвшүүлэх зорилтыг дэвшүүлж оршино.

Үйл ажиллагааны чиглэл:

Баянбулаг сумын ИТХ-ын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ.

Үүнд:

- Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын үйл ажиллагааг ард иргэдэд сурталчлан таниулж, эдийн засаг нийгмийн асуудлыг тууштай шийдвэрлэн хэрэгжилтэд хяналт тавин, орон нутагтаа хэтийн бодлого, шийдвэрийг тодорхой чиглэлтэйгээр гаргаж, хурлын ил тод нээлттэй байдлыг ханган төлөөлөгчдийн үүрэг хариуцлагыг өндөржүүлэхээр үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Баянбулаг сумын ИТХ-ын үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Баянбулаг сумын ИТХ-ын удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна.

Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль
- Зөрчлийн тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй болно.

## 2.5 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА БОЛОН ДОТООД ХЯНАЛТТАЙ ХОЛБООТОЙ ХҮЧИН ЗҮЙЛСИЙН ҮНЭЛГЭЭ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын

шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Баянбулаг сумын ИТХ-ын санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд 41 буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзлээ.

Баянбулаг сумын ИТХ-ын санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн "Санхүүгийн тооцоолох групп" ХХК-ийн "Acolous" программ хангамж ашигладаг байна.

Баянбулаг сумын ИТХ-ын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “Дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт Үр нөлөөтэй гэж үзлээ.

### 2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Баянбулаг сумын ИТХ-ын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 7 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 7 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

### 2.7 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 2 хувиар сонгов.

Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь улсын төсвөөс санхүүждэг төсөвт байгууллагын хувьд

байгууллагын нийт зардлыг суурь үзүүлэлт болгон сонгох нь зохимжтой гэж үзсэнтэй холбоотой юм.

Баянбулаг сумын ИТХ-ын 2018 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 50752,3 мянган төгрөг бөгөөд түүний 2 хувь болох 1015,0 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

## 2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 5 чиглэлээр аудитын 7 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 7 асуудлыг алдаа, зөрчилгүйд тооцсон.

### 2.8.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Байхгүй

## 2.9 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Байхгүй

## 2.10 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Баянбулаг сумын ИТХ-ын чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 49527,6 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 49213,1 мянган төгрөг буюу 99,4 хувьтай байгаа нь Тайлант онд гэрээт ажилчдын цалинг ажлын гүйцэтгэлээр олгосноос цалингийн зардал 314.4 мянган төгрөгөөр хэмнэгдсэн байна.

### 2.11 Шилэн дансны мэдээлэл

Баянбулаг сумын ИТХ-ын Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын “Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн аудит”-аар Шилэн дансны хуулийн 6.1-д заасан мэдээллийн өөрт хамаарах 25 мэдээллээс хугацаа хоцорч мэдээлсэн 7 мэдээлэл байна.

### 2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайланд зөвлөмж аваагүй байна.

### 2.13 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Баянбулаг сумын ИТХ-ын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Баянбулаг сумын ИТХ-ын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 3. Аудит хийсэн санхүүгийн тайлан

### Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,446,125.00** | **1,046,125.00** |
| **33** | **АВЛАГА** | 400,000.00 | 00.00 |
| **335** | **Бусад авлага** | 400,000.00 | 00.00 |
| 3352 | Хувь хүмүүсээс авах авлага | 400,000.00 | 00.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 1,046,125.00 | 1,046,125.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 1,046,125.00 | 1,046,125.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 1,046,125.00 | 1,046,125.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **178,499.07** | **53,832.47** |

| | | | |
|---|---|---|---|
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 178,499.07 | 53,832.47 |
| **392** | **Биет хөрөнгө** | 178,499.07 | 53,832.47 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 6,869,600.00 | 6,869,600.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -6,691,100.93 | -6,815,767.53 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 1,580,400.00 | 1,580,400.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -1,580,400.00 | -1,580,400.00 |
| 39301 | Програм хангамж | 450,000.00 | 450,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -450,000.00 | -450,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **1,624,624.07** | **1,099,957.47** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **1,624,624.07** | **1,099,957.47** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 1,624,624.07 | 1,099,957.47 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 4,903,725.00 | 4,903,725.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 4,903,725.00 | 4,903,725.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | -3,685,100.93 | -4,209,767.53 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | -3,685,100.93 | -3,685,100.93 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | -524,666.60 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 406,000.00 | 406,000.00 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **1,624,624.07** | **1,099,957.47** |

### АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **50,316,676.00** | **50,227,600.00** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **50,316,676.00** | **50,227,600.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 1,000,000.00 | 700,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 1,000,000.00 | 700,000.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 48,666,000.00 | 49,346,800.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 48,666,000.00 | 49,346,800.00 |
| 132004 | Оны эхний үлдэгдлээс санхүүжих / орон нутгийн төсөв/ | 00.00 | 180,800.00 |
| **1330** | **Төсвийн захирагчдаас** | 00.00 | 180,800.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 650,676.00 | 00.00 |
| 134001 | Нийгмийн даатгалын сангаас санхүүжих | 650,676.00 | 00.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **50,518,849.25** | **50,752,266.60** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **50,518,849.25** | **50,752,266.60** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 48,887,373.25 | 50,237,544.60 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 38,698,600.00 | 37,595,432.00 |
| 210101 | Үндсэн цалин | 28,887,754.00 | 37,564,332.00 |
| 210104 | Урамшуулал | 9,810,846.00 | 31,100.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 4,088,200.00 | 4,725,386.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210201 | Тэтгэврийн даатгал | 4,088,200.00 | 3,562,486.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 00.00 | 291,600.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 00.00 | 224,200.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 00.00 | 58,900.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 00.00 | 588,200.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 2,988,800.00 | 4,360,060.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,509,200.00 | 1,733,560.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,170,600.00 | 2,041,200.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 180,000.00 | 60,000.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 65,000.00 | 100,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 64,000.00 | 00.00 |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | 00.00 | 425,300.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 458,500.00 | 1,120,500.00 |
| 210502 | Хоол, хүнс | 458,500.00 | 1,120,500.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1,456,700.00 | 2,291,500.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,456,700.00 | 2,291,500.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,020,000.00 | 20,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,020,000.00 | 20,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 176,573.25 | 124,666.60 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 176,573.25 | 124,666.60 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 1,631,476.00 | 514,722.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 1,450,676.00 | 200,000.00 |
| 213203 | Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж | 650,676.00 | 00.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 800,000.00 | 200,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 180,800.00 | 314,722.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 180,800.00 | 314,722.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **-202,173.25** | **-524,666.60** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **-202,173.25** | **-524,666.60** |

## АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **50,316,676.00** | **50,227,600.00** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **50,316,676.00** | **50,227,600.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 1,000,000.00 | 700,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 1,000,000.00 | 700,000.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 48,666,000.00 | 49,527,600.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 48,666,000.00 | 49,346,800.00 |
| 132004 | Оны эхний үлдэгдлээс санхүүжих / орон нутгийн төсөв/ | 00.00 | 180,800.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 650,676.00 | 00.00 |
| 134001 | Нийгмийн даатгалын сангаас санхүүжих | 650,676.00 | 00.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **50,316,676.00** | **50,227,600.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **50,316,676.00** | **50,227,600.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **48,685,200.00** | **49,712,878.00** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 38,898,600.00 | 37,305,918.00 |
| 210101 | Үндсэн цалин | 29,087,754.00 | 22,947,316.00 |
| 210104 | Урамшуулал | 9,810,846.00 | 11,108,340.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 00.00 | 3,250,262.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 4,088,200.00 | 4,498,900.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 4,088,200.00 | 2,699,800.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 00.00 | 397,100.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 00.00 | 317,700.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 00.00 | 79,400.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 00.00 | 1,004,900.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 2,446,900.00 | 3,838,860.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,277,600.00 | 2,128,860.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 924,300.00 | 1,520,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 245,000.00 | 90,000.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 00.00 | 100,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 458,500.00 | 888,000.00 |
| 210502 | Хоол, хүнс | 458,500.00 | 888,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1,773,000.00 | 2,461,500.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,773,000.00 | 2,461,500.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,020,000.00 | 719,700.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,020,000.00 | 719,700.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **1,631,476.00** | **514,722.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 1,450,676.00 | 200,000.00 |
| 213203 | Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж | 650,676.00 | 00.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 800,000.00 | 200,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 180,800.00 | 314,722.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 180,800.00 | 314,722.00 |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 00.00 | 00.00 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 00.00 | 00.00 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 00.00 | 00.00 |

## АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| C08 | **2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **00.00** | **00.00** | **00.00** | **00.00** | 00.00 |
| D01 | **2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **4,903,725.00** | **406,000.00** | **-3,685,100.93** | **00.00** | 1,624,624.07 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **4,903,725.00** | **406,000.00** | **-3,685,100.93** | **00.00** | 1,624,624.07 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | -524,666.60 | 00.00 | -524,666.60 |
| D09 | **2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **4,903,725.00** | **406,000.00** | **-4,209,767.53** | **00.00** | 1,099,957.47 |

## 1.5. АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

**/төгрөгөөр /**

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Өмнөх оны | | Тайлант оны | |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 48,661,000.00 | 49,485,200.00 | 49,346,800.00 | 49,613,178.00 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 48,661,000.00 | 49,485,200.00 | 49,346,800.00 | 49,613,178.00 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 47,861,000.00 | 48,685,200.00 | 49,146,800.00 | 49,413,178.00 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 38,898,600.00 | 38,898,600.00 | 37,620,200.00 | 37,705,918.00 |
| 210101 | Үндсэн цалин | 28,405,200.00 | 29,087,754.00 | 25,908,200.00 | 23,347,316.00 |
| 210104 | Урамшуулал | 10,493,400.00 | 9,810,846.00 | 8,112,000.00 | 11,108,340.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 00.00 | 00.00 | 3,600,000.00 | 3,250,262.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 4,088,200.00 | 4,088,200.00 | 4,498,900.00 | 4,498,900.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 4,088,200.00 | 4,088,200.00 | 2,910,500.00 | 2,699,800.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 00.00 | 00.00 | 397,100.00 | 397,100.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 00.00 | 00.00 | 317,700.00 | 317,700.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 00.00 | 00.00 | 79,400.00 | 79,400.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 00.00 | 00.00 | 794,200.00 | 1,004,900.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 2,446,900.00 | 2,446,900.00 | 3,838,900.00 | 3,838,860.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,277,600.00 | 1,277,600.00 | 2,128,900.00 | 2,128,860.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 924,300.00 | 924,300.00 | 1,520,000.00 | 1,520,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 245,000.00 | 245,000.00 | 90,000.00 | 90,000.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 00.00 | 00.00 | 100,000.00 | 100,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 458,500.00 | 458,500.00 | 888,000.00 | 888,000.00 |
| 210502 | Хоол, хүнс | 458,500.00 | 458,500.00 | 888,000.00 | 888,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1,918,800.00 | 1,773,000.00 | 2,280,800.00 | 2,461,500.00 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210702 | Дотоод албан томилолт | 1,918,800.00 | 1,773,000.00 | 2,280,800.00 | 2,461,500.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 50,000.00 | 1,020,000.00 | 20,000.00 | 20,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 50,000.00 | 1,020,000.00 | 20,000.00 | 20,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 800000.00 | 800000.00 | 200000.00 | 200000.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 800,000.00 | 800,000.00 | 200,000.00 | 200,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 800,000.00 | 800,000.00 | 200,000.00 | 200,000.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 48,666,000.00 | 48,485,200.00 | 49,346,800.00 | 49,032,378.00 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 48,666,000.00 | 48,485,200.00 | 49,346,800.00 | 49,032,378.00 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 48,666,000.00 | 48,485,200.00 | 49,346,800.00 | 49,032,378.00 |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **00.00** | **-1,000,000.00** | 00.00 | 00.00 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 03.00 | 03.00 | 03.00 | 03.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 01.00 | 01.00 | 01.00 | 01.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 01.00 | 01.00 | 01.00 | 01.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 01.00 | 01.00 | 01.00 | 01.00 |